



НОГООН ТЭЖЭЭЛ

Архангай аймгийн
Өндөр-улаан
сумын БАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 6- 10 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ 3.720.000

Төсөл хэрэгжсэн газар

Архангай аймаг Өндөр-улаан сум

Төслийн зорилго

Малын нэмэгдэл тэжээлийн нөөц бүрдүүлэх замаар бэлчээрийн даац ачааллыг бууруулах.

Төслийн зорилтууд

4 га талбайд БАХ-ийн ахлагчид болон малчид хамтран ногоон тэжээл тариалах.

Үйл ажиллагаа

Төслийн хүрээнд Өндөр-улаан сумын СБАХ болон Бэлх багийн Даахь БАХ-ийн малчид хамтран 4 га талбайд ногоон тэжээл тариалсан.

2020 оны 9 дүгээр сарын 25-10 сарын 01-ны өдрүүдэд тэжээл хураалтын ажлыг зохион байгуулж нийт 20 тонн орчим ногоон тэжээл бэлтгэн БАХ-ийн малчид өвөлжилтийн бэлтгэлээ

хангалаа. Ногоон тэжээл хадах ажлыг БАХ-ийн малчид өөрсдийн пад, пад бага оврын трактор техник хэрэгслээр хадлаа.

Төслийн хөрөнгө оруулалт

Төсөл хэргжүүлэхэд нийт 3,7 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байсныг НАМЭМ төсөл болон малчдаас хамтран хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлсэн болно.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	2.000.000
ОНХС	0
СБАХ	
Малчид	1,720,000
Нийт	3,720,000



Зураг

Хөрс боловсруулалтын үйл явц



Зураг

Тэжээл хураалтын үйл явц

Сургам: COVID 19 цар тахал болон бусад шалтгааны улмаас тэжээлийн үрийн хомсдол үүссэн зэрэг, орон нутагт худалдаалагдаж буй үрээс сонголтгүй авч тариалалт хийсэн нь ургац төлөвлөсөн хэмжээнд хүрч ургаагүй. Цаашид үрийг лабораторын шинжилгээгээр батлагдсан сайн чанарын үр худалдаж авах хэрэгтэй гэдгийг мэдсэн.

Өндөр-улаан сумын хувьд газар тариалан эрхлэлт төдийлөн байхгүй тул ногоон тэжээл тарихад техник хэрэгслийн дутагдал хүндрэлтэй байлаа.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Үр худалдаж авах	кг	800	900	720,000
2	Хөрс боловсруулалт, тарилт	Га	4	450,000	1,800,000
3	Тэжээл хураалтын зардал	Га	4	100,000	400,000
4	Хашаа засварлах	ш	1	800,000	800,000
	Нийт				3.720.000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Ногоон тэжээл	тн	10	300.000	3.000.000
2	Ногоон тэжээл /төсөл хэрэгжүүлэгч өрхийн хэрэгцээнд/	Тн	10		
	Нийт				3,000,000

төслийн хүрээнд нийт 20 тнн ногоон тэжээл бэлтгэж 10 тоныг нь зах зээлийн ханшаас 20 %-ийн хөнгөлөлттэй үнээр БАХ-ийн малчдад борлуулж нийт 3 сая төгрөгийг орлогыг бүрдүүлэ дараа жилийн тариалатын зардлын сангаа бүрдүүлж, үлдсэн 10%-ийг төсөл хэрэгжүүлэгч малчид мал өвөлжилтийн бэлтгэл өвс тэжээлийн нөөцөө хангахад зориулж 10 өрхийн хэрэгцээг хангасан байна.

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ борлуулалт нэмэгдсэн байдал,
- ↑ шинээр бий болсон бүтээгдэхүүн,
- ↑ шинээр бий болсон хөрөнгө,
- ↑ цэвэр ашиг,

- ↑↑ нийгмийн ашиг тус,
- ↑↑ амьжиргааны түвшин, орлого нэмэгдсэн байдал,
- ↑↑ шинээр нэмэгдсэн ажлын байр,
- ↑↑ үр шим хүртсэн хүмүүсийн тоо г.м

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Төслийн үр шимийг хүртэгч Өндөр-улаан сумын Бэлхи багийн Даахь БАХ-ийн малчин Жаргалсайхан: Малчдад үнэхээр хэрэгтэй ажил боллоо. Ялангуяа Өндөр-улаан сум бол нэгдлийн үед газар тариалан эрхэлж байгаад зах зээлд шилжсэн 30 жил энэ төрлийн ажил хийгдээгүй малчид бид хамгийн ойрдоо 120 км буюу Их-тамираас ногоон тэжээл худалдаж авдаг. Швейцарын хөгжлийн агентлагийн НАМЭМ төсөлд талархал элэрхийлъя.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

ногоон тэжээл тариалах.